



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 8/61

Хөхбүрд

Гадна аймаг сумдаас орж ирсэн отрын
айлуудыг нүүлгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дэх заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн "Бэлчээр ашиглалтын үлгэрчилсэн журам батлах тухай" 03/12 дугаар тогтоолын 4.5.2, 6.3.4 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гадны аймаг сумаас орж ирсэн малчин өрхүүд нь тус сумын Мандалхайрхан 1 дүгээр баг, Уранхайрхан 2 дугаар багийн Иргэдийн нийтийн хурлаар чөлөөлсөн малын өвөлжөө хаваржаанд малаа бэлчээрлүүлж байгаа талаар малчдаас гомдол асар ихээр ирж байгаа тул тэднийг нүүлгэн шилжүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Гүндцамба (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Гишүүдэд: Т.Цэцэгсайхан (Мандалхайрхан 1 дүгээр багийн Засаг дарга)

С.Энх-Амгалан (Уранхайран 2 дугаар багийн Засаг дарга)

М.Сэр-Од (Асгамба 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Дагдансүрэн (Мэргэн 4 дүгээр багийн Засаг дарга)

Б.Үлэмжсонин (Татварын байцаагч)

2. Отроор ирсэн малчин өрхийг 2023 оны 08 дугаар сарын 07-ноос 10-ны өдрийн хооронд нүүлгэх ажлыг зохион байгуулсугай.

3. Дурдсан хугацаанд дээрх ажлыг зохион байгуулж ажиллаагүй Багийн Засаг дарга болон ажлын хэсгийн ахлагчид хуулийн дагуу хариуцлага тооцохыг анхааруулсугай.

4. Бэлчээрийн үлгэрчилсэн журмын дагуу гадны аймаг сумдаас орж ирсэн малчин өрхөөс байсан хоног тутмын татварыг бодож нэхэмжлэл үүсгэн хураан авч орон нутгийн дансанд төлвөрүүлэн ажиллахыг татварын байцаагч (Б.Үлэмжсонин)-д хариуцуулсугай.

642301123

5. Дээрх ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулж тайлагнахыг Хөдөө аж ахуйн тасгийн дарга (Л.Гүндцамба)-д, Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)-д даалгасугай.

ДАРГА



Г.ОРХОНТУУЛ